



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/105

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, чиглэл
нэмэх, төсөл нь дэмжигдээгүй буюу 1 жилийн
хугацаанд хүлээн авахгүй байх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 15 дугаар зүйлийн 15.12.2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.3.4, 19.18, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/400 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.1.1, “Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл” олгох комиссын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, чиглэл нэмэх байгууллагын нэрсийг нэгдүгээр, төсөл нь дэмжигдээгүй байгууллагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газарт үүрэг болгосугай.


ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 010105

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 17-ны
өдрийн 17 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ, ЧИГЛЭЛ НЭМЭХ БАЙГУУЛЛАГЫН НЭР

№	Байгууллагын нэр (РД)	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллага				
1	Эл ар эм жи эл ХХК РД6337848	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	ХУД, Махатма Гандийн гудамж, 17-р хороо, Хаус 2-2 тоот	2025.04.25
2	Лимитлэс лайт ХХК РД6826482	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 1-р хороо, Үйлдвэрчний төв гудамж, 402-101А	2025.04.25
3	Серина бюти ХХК РД6481388	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 5-р хороо, МН тауэр 16 давхарт 1608 тоот	2025.04.25
4	Новитас ХХК РД6449808	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	БГД, 4-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 92-р байр 1 давхарт	2025.04.25
5	Нарны үндэс ХХК РД5339081	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	СХД, 15-р хороо, 1-р хороолол Москвагийн гудамж, 44 тоот	2025.04.25
6	Эс икс би ХХК РД5221293	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	СХД, 14-р хороо, Өнөр хороолол, залуусын гудамж 35/3 байрны 3 давхарт 301, 302 тоот	2025.04.25

Хоёр. Тусгай зөвшөөрлийн чиглэл нэмэх байгууллага				
1	Өөжинмед ХХК РД5886805	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	БЗД, 3-р хороо, 12-р хороолол, 32-р байранд	2023.05.21
Гурав. Шинээр олгож, чиглэл нэмэх байгууллага				
1	Энто ХХК РД5020166	Лабораторийн урвалж, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 3-р хороо, Худалдааны гудамж 44-р байр	2025.04.25

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 8 дугаар сарын 1-ны
өдрийн 47 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ТӨСӨЛ ДЭМЖИГДЭЭГҮЙ БАЙГУУЛЛАГЫН НЭР

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
	Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/400 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад заасны дагуу 1 жилийн хугацаанд дахин хүлээн авахгүй байх байгууллага	
1	Био реагент ХХК	Эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх